



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар A/487

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.1, "Централ секюритийз ҮЦК" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 26/25 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн A/96 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь хязгаарласан "Централ секюритийз ҮЦК" ХХК нь гаргасан зөрчлөө арилгаж, үйлчилгээний хөлсөө төлсөн тул арилжаанд оролцох эрхийг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. "Централ секюритийз ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үгийг сэргээхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
3. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг "Централ секюритийз ҮЦК" ХХК (Б.Мөнгөншагай)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн A/96 дугаар тушаалын "Централ секюритийз ҮЦК" ХХК-д хамаарах хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХАШ-ЭРДЭНЭ

1525831020